

Цагаантолгой ХК

2022/3/19

ТУЗ № 3

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлын Тогтоол

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.1, 7 дугаар зүйлийн 7.1.13, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цагаантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 6-р баг, Сүхбаатарын талбайн зүүн урд Модерн Номадс буудалд зохион байгуулахаар товлосугай.
2. “Цагаантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - 1.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөл болон ТУЗ-ийн хараат бус гишүүдийг батлах
 - 1.3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
 - 1.4. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
 - 1.5. Ногдол ашиг хуваарилахгүй талаархи тайлбар, мэдээлэл
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
4. Ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, 2022 оны 03 дугаар сарын 23, ба 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд болон нийтэд мэдээллэх, брокер дилерийн компаниудад ээлжит хурлын зарыг цахимаар хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Наранчимэгт даалгасугай.

Цагаантолгой ХК

5. Хурлын тооллогын комиссын даргаар Т.Мөнхбаяр, гишүүдэд П.Пүрэвсүрэн, Э.Энхжаргал нарыг тус тус томилсугай.
6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загварыг Хавсралт №01-ээр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №02-оор, саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчийн санал авах хуудасны агуулгыг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээлэл, баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2022 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөр тогтоосугай.
8. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 18:00 цагаар тогтоосугай.
9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах, зохион байгуулах комиссын даргаар Т.Ууганбаяр г, комиссын гишүүдэд ТУЗ-ийн гишүүн Л.Болдбаатар , ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Наранчимэг нарыг тус тус томилсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор буюу 2022 оны 03 дугаар сарын 27-ны дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид Монголын хөрөнгийн биржийн сайтад бүртгэгдсэн и-мэйл хаягаар хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Наранчимэгт үүрэг болгосугай.
11. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.Янжинлхам